



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГИЙН ГАЗАР



Asian Development Bank

АЗИЙН ХӨГЖЛИЙН
БАНК



ШИНЭ ДАЗТВ

ГЭР ХОРООЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР

УЛААНБААТАР ХОТЫН
ГЭР ХОРООЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ
ХӨТӨЛБӨР

ТӨСӨЛ 1-ИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот 2018





ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх өрөнхий төлөвлөгөөний тодотгол 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичиг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Азийн Хөгжлийн банк болон Европын Хөрөнгө Оруулалтын банкны хөнгөлөлттэй зээлээр "Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийг хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Төслийн хүрээнд хотын нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах зорилгоор нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэхээр тусган Улаанбаатар хотыг 6 дэд төвтэй байхаар төлөвлөсөн. Төсөл 3 ѿ шаттайгаар нийт 9 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд Төслийн I шатны хүрээнд Сэлбэ (156 га), Баянхошуу (162 га) дэд төвүүд нь нийт 318 га газар нутгийг нийслэлийн хойд бүсийн хүн амд үйлчилдэг, худалдаа, соёл үйлчилгээний төвлөрөл бүхий байгаль орчинд ээлтэй ногоон орчинг бүрдүүлсэн дүүрэг бүсийн чанартай төв болгон хөгжүүлэх суурь навхцлийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хөтөлбөрийг Улаанбаатар хотын санаачлагаар 2008 оноос эхлэн боловсруулсан ба үүнд АХБ дэмжлэг үзүүлэн МОН-7591; МУ-ын УБ хотын цэвэр ба бохир усны үйлчилгээ ба төлөвлөлтийг сайжруулах техникийн туслалцаа, МОН-7970; УБ хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрийн техникийн туслалцааны төспүүдийг хэрэгжүүлсэн. АХБ-ны хэрэгжүүлсэн эдгээр техникийн туслалцааны төслүүдийн үр дунд тулгуурлан Улаанбаатар хотын захиргаа хөтөлбөрийг санаачилсан ба АХБ-наас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүссэн. Уг хүсэлтийг АХБ дэмжсэнээр Монгол Улс ба АХБ хооронд Санхүүжилтийн Ерөнхий Хэлэлцээрийг 2013 оны 12 дугаар сарын 9-ний өдөр байгуулсан юм.

Хөтөлбөрийн Төсөл 1 ба 2 нь "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх өрөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг". МУ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.8, 1.2.9, 2.3.1, 2.4.22, 2.4.17 дахь заалтуудыг хэрэгжүүлэхтэй нягт уялдаа холбоотой байна. Тухайлбал, эхний шатанд Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд хөгжлийн суурь болох дэд бүтцийг шинээр тавих, дэд төвийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах. 2-р шатанд Дамбадаржаа. Дэнжийн мянга дэд төвүүдийг хөгжүүлэх төслийн ТЭЗҮ боловсруулж, бэлтгэл ажлыг хангах зэрэг үйл ажиллагаанууд цогц байдлаар туссан байна. Иймд, төслийн үйл ажиллагаа нь МУ-ын Засгийн газар болон Нийслэлийн хэрэгжүүлж буй бодлсго, үйл ажиллагаатай уялдаа холбоотой төдийгүй тэдгээрийн зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн тул цаашид үргэлжлүүлэх нь УБ хотын хөгжлийн үзэл баримтлалд нийцэж байгаа болно.

Хөтөлбөр хэрэгжсэнээр гэр хорооллын автозам, нийгмийн болон инженерийн дэд бүтэц цогцоор шийдэгдсэн уялдаа бүхий шинэ дэд төвүүд бий болж Улаанбаатар хотын төвлөрөл, агаар хөрсний бохирдол буурч, дэд төвүүдийг орон сууцжуулах суурь нехцөл бүрэн хангагдах юм.



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТЕЛБЕР

ЗОРИЛГО:

Хөтөлбөрийн эрхэм зорилго нь эдийн засгийн боломж, орон сууц, хотын дэд бүтцийн үйлчилгээ хангамж бүхий эрүүл, аюулгүй, тав тухтай амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлсэн, бие даан хөгжсөн дэд төвийн сүлжээг гэр хороололд бий болгон хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах нөхцлийг бий болгоход оршино. Хөтөлбөрийн эхний үе шатанд Баянхшуу. Сэлбэ дэд төвүүдийг хотын дэд төв болон хөгжих суурь нөхцлийг:

Инженерийн дэд бүтцийг цогцоор нь шийдэх замаар буюу биет хөрөнгө оруулалт бүхий бүтээн байгуулалтын ажлуудаар. мөн зорилтот дэд төвүүдийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх

ТӨСЛИЙН 1-РҮЕ ШАТ ХЭРЭГЖСЭНЭЭР:

- Баянхшуу, Сэлбэ дэд төвд нийт 7.57 га талбай бүхий ногоон байгууламж бий болж, хотын ногоон байгууламж нэмэгдэнэ.
- Баянхшуу, Сэлбэ дэд төвд тус бүр 240 хуухдийн хүчин чадал бүхий цэцэрлэг байгуулж, ашиглалтанд оруулснаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.
- Баянхшуу, Сэлбэ дэд төвд тус бүр 1 ээлжиндээ 100 суралцагч хүлээн авах хүчин чадал бүхий бизнес инкубатор болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байгуулагдан ашиглалтанд орсноор дэд төвийн бизнес эрхлэгчид, ажил хайгч иргэдэд төрийн үйлчилгээг хургэх боломжийг нэмэгдүүлнэ.
- Баянхшуу, Сэлбэ дэд төвүүдэд инженерийн дэд бүтцийг цогцоор нь бий болгосноор дэд төв барилгажих боломжтой болох ба дэд төвийн хөгжлийн төлөвлөгөөг төр. хувийн хэвшил, иргэдийн оролцоог зөв зохицуулан хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛУУД

- Дулаан хангамж
- Усан хангамж, ариутгах татуурга
- Авто замын сүлжээ
- Цахилгаан, холбоо
- Нийгмийн барилга байгууламж бий болгоно.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ:

"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол. 2030 оны хөгжлийн чиг хандлага" баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбоотой НЭД-ын үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөөнд тусгагдсан "Дэд төв"-үүдийн инженерийн шугам сүлжээ, байгууламжийг үе шаттайгаар барьж байгуулах.

ХҮРЭХТҮВШИН:

Улаанбаатар хотын Баянхшуу, Сэлбэ дэд төвүүдэд төлөвлөлтийн шийдлийн дагуу инженерийн шугам сүлжээ, байгууламж барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн гэр хорооллын авто зам, нийгмийн болон инженерийн дэд бүтэц цогцоор шийдэгдсэн уялдаа бүхий дэд төвүүд бий болон Улаанбаатар хотын агаар, хөрсний бохирдол буурахаас гадна иргэдэд хүрэх эдийн засгийн болон төрийн үйлчилгээний хүртээмж сайжрах, нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний үр ашиг нэмэгдэх. хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагуудын чадавхи бэхжих зэрэг боломж бүрдэх юм.



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХЕРЕНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХХ БАЙНА

Төслийн Ye шат 1-ийн хүрээнд 2018 оны эцсийн байдлаар Сэлбэ, Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээ, авто зам, нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилт 69.34%-тай байна. Үүнд төслийн худалдан авах ажиллагааны хэрэгжилт 94.57%, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн ажлын явц 94.12%-тай байна. Нийт 27 төсөл арга хэмжээнээс 11 төсөл арга хэмжээний барилга угсралтын ажил 2018 онд эхэлж, Баянхошуу дэд төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 26.69% орчим, Сэлбэ дэд төвийн гүйцэтгэл 17.02%-тай хэрэгжиж байна.

САНХҮҮЖИЛТИЙН ЭХҮҮСВЭР:	Азийн хөгжлийн банк (AXB)-ны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусlamж Европын хөрөнгө оруулалтын банк (EXOB)-ны хөнгөлөлттэй зээл Монгол Улсын Засгийн Газар – Нийслэлийн Засаг даргын Тамгын Газрын Хөрөнгө оруулалт	
ТӨСЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:	• Баянхошуу, Сэлбэ дэд төвд нийт 7.57 га талбай бүхий ногоон байгууламж бий болж, хотын ногоон байгууламж нэмэгдэнэ.	
ТӨСЛИЙН ӨРТӨГ:	Ye шат-1 AXB-наас 19.78 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 27.5 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл, 3.7 сая ам.долларын буцалтгүй тусlamж; EXOB-наас 22.01 сая долларын зээл; Монгол Улсын Засгийн газраас 33.15 сая ам доллар. Нийт 106.14 сая ам доллар	Ye шат-2 AXB-наас 29.24 сая ам.долларын зээлжих тусгай эрх бүхий зээл, 37.11 сая ам.долларын ердийн эх үүсвэрийн хөнгөлөлттэй зээл; EXOB-наас 19.64 сая еврэгийн зээл; Монгол Улсын Засгийн газраас 35.15 сая ам доллар. Нийт 121.14 сая ам доллар.
ТӨСЛИЙН ХУГАЦАА:	I Ye шат: 2014.09.01 - 2019.12.31	II Ye шат: 2017 оны 12-р сар - 2022 оны 2-р сарын 28
ТӨСЛИЙН ЯВЦ:	I Ye шат: 69.34 хувь	II Ye шат: 10 хувь

Хүснэгт 1. 2018 оны 12 дугаар сар



2. 2018 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУД:

УСУГ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах дэд төслийн хүрээнд Үйлдвэр, Max. Төв болон Гачуурт насос станцуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, түгээх сүлжээний удирдлагын болон хэмжихи худгуудын барилга угсралт. УСУГ-ын төвийн удирдлагын төвд СКАДА систем, усны алдагдлыг илрүүлэх систем суурилуулж ашиглалтад оруулах зэрэг ажлуудыг 100% хийж гүйцэтгэсэн. Шилэн кабель суурилуулалтын ажил хийгдэж дууссан. Үйлдвэрийн станцын удирдлагын системийг ашиглалтад оруулж ажиллагааг жигдруулсэнээр 1 ба 2-р өргөгчийн насос станцыг хянан удирдаж хяналтын хаалт угсралтын шинэчилсэн графикийг холбогдох хүмүүсээр батлуулан ажиллаж байна. УСУГ-ын нэгдсэн удирдлагын төвийн програм хангамжийн ажлыг 100% гүйцэтгэсэн. 2018.12.31-ны байдлаар тус ажлын хүрээнд хийх дэд ажлуудыг бүрэн хийж дууссан. Үүнд:

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн ажлын хүрээнд:

- Ус хангамжийн эх үүсвэрүүдэд насосны давтамж хувиргагч, шилэн кабель, өргөлтийн насоснууд суурилуулж автоматжуулалт хийгдсэн.
- Ус хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 худгийн 30 худгийг шинээр барьж, 10 худгийг шинэчлэн засварласан.
- Төв цэвэрлэх байгууламжийн SCADA программ, шилэн кабелийн суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн.

Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслийн хүрээнд Төвийн эх үүсвэрийн 6кВ-ын 750кВт-ын хүчин чадал бүхий цахилгаан хөдөлгүүрт Harvest Schneider брэндийн давтамж хувиргагчийг суурилуулсан. Уг давтамж хувиргагчаар З насос хөдөлгүүрийг удирдан ажиллуулах бүрэн боломжтой болсон.



Давтамж хувиргагчийн ерөнхий удирдлагын дэлгэц дээр үндсэн үзүүлэлт болон шаардлагатай параметрууд гардаг бөгөөд бид насос болон цахилгаан хөдөлгүүрийг гаралтын шугам дээр тавигдсан даралтын мэдрэгчийн мэдээлэлээр удирдан ажиллуулж байна. Энэ нь дэлгэц дээр шаардлагатай байгаа даралтыг өгсөнөөр уг тоноглол өгөгдсөн утгыг барьж ажилладаг ухаалаг төхөөрөмж юм.



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХХ ХӨТӨЛБӨР

САРУУД:	2015	2016	2017	2018
1	0.72	0.70	0.76	0.65
2	0.71	0.75	0.67	0.59
3	0.68	0.64	0.68	0.55
4	0.60	0.68	0.55	0.49
5	0.80	0.60	0.61	0.53
6	0.62	0.69	0.62	0.46
7	0.61	0.60	0.59	0.55
8	0.60	0.64	0.59	0.51
9	0.69	0.67	0.52	0.41
10	0.62	0.59	0.54	0.45
11	0.68	0.74	0.55	0.37
12	0.65	0.55	0.56	
	0.66	0.65	0.61	0.51

Хүснэгт 2. Хэмжих хэрэгсэл болон электрон тоолуураар гарсан тоон үзүүлэлт


Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй уялдуулан давтамж хувиргагчийг сууринуулсан нь энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд дөхөм болж байна. Давтамж хувиргагчийг сууринуулсанаар өмнөх 3 жилийн дундажаар 1м3 усыг 0,64кВт.ц эрчим хүчээр олборлон түгээдэг байсан бол 2018 онд 0,51кВт.ц болж 0,12кВт.ц эрчим хүчээр буурч эрчим хүчиний хэмнэлттэй ажиллаж эхэлсэн.

- АВТОМАТЖУУЛАЛТЫН АЖИЛ

УСУГ-ын ус хангамжийн 4 эх үүсвэрийн станцуудын алсын удирдлагын шилэн кабель, холболтын төхөөрөмжүүдийг сууринуулах ажил бүрэн дууссан. Диспетчерийн өрөөнд хянан ажиллаж байна.




Махын эх үүсвэрийн станц



Гачууртын эх үүсвэрийн станц

Хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд УСУГ-ын үйл ажиллагаанд Эрчим хүчиний хэмнэлттэй орчин үеийн шаардлагад нийцсэн цахилгаан тоног төхөөрөмж нэвтрүүлэн ус хангамжийн эх үүсвэрүүдэд насосны давтамж хувиргагч, шилэн кабель, өргөлтийн насоснууд суурилуулан автоматжуулалт хийж, ус хангамжийн шугам сүлжээнд хэмжилтийн 40 худгийн 30 худгийг шинээр барьж, 10 худгийг шинэчлэн засварлан Төв цэвэрлэх байгууламжийн SCADA программ, шилэн кабелийн суурилуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Ингэснээр эрчим хүчиний хэрэглээ буурч 0,12кВт.ц-н хэмнэлттэй ажиллаж эхэллээ.



Үйлдвэрийн эх үүсвэрийн станц



БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛИЙН БАЙДАЛ

1. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 8-Р ХОРОО, БАЯНХОШУУ ДЭД ТӨВД БАРИХ 240 ХҮҮХДИЙН ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Гүйцэтгэгч: "Ус Орчин" ХХК
Хүчин чадал: 240 Хүүхдийн
цэцэрлэгийн барилга
Байршил: Баянхошуудэд төв
Ажлын явц: 100%

Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянхошуу дэд төвд барьсан 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг Нийслэлийн газрын албанаас 2018 оны 04 сарын 16-ны өдөр. МЗХ2018/07-49 тоот архитектур төлөвлөлтийн даалгаврыг 2018 оны 04 сарын 20-нд. 138/2018 тоот барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2018 оны 05 сарын 07-ны өдөр НХТЭТГ-аас авсан.

2018.11.16-ны өдөр уг барилгыг байнгын ашиглалтанд оруулах улсын комисс амжилттай ажиллаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, өмчид бүртгүүлэх зэрэг ажлуудыг хийсэн.

Уг барилгыг ашиглагчид хүлээлгэн өгөхдөө багш, хүүхдийн иж бүрэн тавилга, гол тогооны тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгсөн юм. Ингэсээр 261 дүгээр цэцэрлэг нь 2018.12.15-наас албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.



Тус цэцэрлэг нь 10 бүлэгт 240 хүүхдийг хүлээн авах хүчин чадалтай ба нийт 41 багш ажилчид ажиллана. Одоогийн байдлаар 7 бүлэгт нийт 199 хүүхэд хүлээн авч 31 багш ажилчид ажиллаж байна.

Цэцэрлэгт хамрагдсан хүүхдүүдийг хороо, нас, хүйсээр нь авч үзвэл:

-	7-Р ХОРОО	8-Р ХОРОО	9-Р ХОРОО	10-Р ХОРОО	28-Р ХОРОО	БУСАД	ЭМ	ЗР	Нийтхүүхэд
2 нас	22	63		3	4		46	46	92
3 нас	22	23	1		2	1	27	22	49
4 нас	11	25		3	2	1	23	19	42
5 нас	5	10				1	6	10	16
Нийт	60	121	1	6	8	3	102	97	199

1. Хүүхдийн сурч хөгжих таатай орчинг бүрдүүлэхийн тулд багш нар сургалтын сэдвийн хүрээнд өөрсдийн нөөц боломжийг сургалтын өрөөнүүдээ ашиглан тохижуулж байна.



2. Бүлгүүд ариун цэврийн өрөөндөө хальтрахаас сэргийлсэн гишгүүртэй болсон.



3. Анги танхим, хүлээн авах өрөө, ариун цэврийн өрөөг хүүхэд сурхах хөгжих таатай орчинг бүрдүүлэн тохижуулсан.



4. СХД-ийн 8-р хорооны өрхийн эмч нартай хамтран "Томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх нь", "Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг ахлах бэлтгэл бүлгийн хүүхдүүдийн 30 гаруй эцэг эхчүүдэд зохион явуулж, тэдэнтэй хамтран ахлах ёлтгэл бүлгийн 50 хүүхдэд амны хаалт, мөн дунд бүлгийн 30 гаруй хүүхдэд 3 сар хэрэглэх витамин тараасан.



5. Цэцэрлэгийн үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах үүднээс эцэг эхийн мэдээллийн төв, эмч зөвлөж байна, гол тогооны мэдээлэл, дотоод хяналт шалгалтын самбаруудыг шинээр хийж мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэн хүргэж байна.



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХХ ХӨТЕЛБАР

2. БАЯНХОШУУ ДЭД ТӨВИЙН ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН СУВГИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Гэрээний дугаар: BSDF07, Lot 1
Гүйцэтгэгч: "Хангилцаг" ХХК
Хүчин чадал: 2.3 км
Байршил: Баянхошуудэд төв

Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын 119/2018 тоот барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг журмын дагуу НХТЭТГ-аас 2018 оны 05 сарын 01 өдөр авч, 2018 оны 04 сарын 16-наас барилга угсралтын бэлтгэл ажлыг хангаж далангийн ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгав.

Хангилцаг ХХК нь Баянхошуу дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн ажлыг 100% гүйцэтгэж, 2018.10.02-ны өдөр байнгын ашиглалтанд оруулах Улсын Комисст ажиллаж ашиглагч байгууллага болох Геодези, усны барилга байгууламжийн газарт хүлээлгэн өглөө.

Ажлын Явц: 100%





ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ ХӨӨЖКҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХХ ХӨТӨЛБӨР

3. СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ҮЕРИЙН ХАМГААЛАЛТЫН СУВГИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Гэрээний дугаар: BSDF07 Lot2

Гүйцэтгэгч: "Экспресс Зам" ХХК

Хүчин чадал:

- Үерийн хамгаалалтын суваг 2.1 км
- Замын ус зайлуулах хоолой, сувгийн хамгаалалтын хайсны угсралт – 500 м
- Автозамын дагуу ус зайлуулах шугам хоолой – 500 м

Байршил: Сүхбаатар дүүрэг

Сэлбэ дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын 133/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу НХТETГ-аас 2018 оны 05 сарын 03 өдөр авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн ба гүйцэтгэгч Экспресс зам ХХК-ийн ажлын гүйцэтгэлийн явц 70%-тай хэрэгжиж байна.

Барилга угсралт, суурилуултыг бүрэн хийж гүйцэтгэсэн, технологийн хувьд бусдаасаа хамааралгүй эхний 5 сувгийг байнгын ашиглалтанд оруулах улсын комисс 2018.11.22-нд ажиллаж 1.71км урттай эхний 5 суваг болон замын ус зайлуулах хоолой, сувгийн хамгаалалтын хайсны угсралт 500м байнгын ашиглалтад оруулаад байна.

Суваг №6 ба №7-ийн ажилууд автозамын дагуу хийгдэх тул "Вайт финикс" ХХК-ний автозамын ажилтай уялдуулан гүйцэтгэж байна. Ирэх 2019 онд "Вайт финикс" ХХК-ний ажилтай уялдуулан үлдсэн 890м үерийн хамгаалалтын сувгийг хийж гүйцэтгэнэ. Үлдсэн сувгийн бетон хийц, бусад материалыг үйлдвэрт хийж бэлтгэсэн бөгөөд ажлыг ирэх онд үргэлжлүүлэхэд бэлэн болсон.

Ажлын Явц: 70%



4. ОРОС 14-Р СУРГУУЛЬ ОРЧМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БОХИРЫН ТАТУУРГЫН ГОЛ ЦУГЛУУЛАХ ШУГАМЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Гэрээний дугаар: WSNR17C

Гүйцэтгэгч: "Модерн Хас" ХХК,

"Монгол Менежмент" ХХК-иудын түншлэл

Хүчин чадал:

- 543 метр урттай Ф400мм-ийн ОКП146100 резинэн жийргэвчтэй ширмэн хоолой

Байршил:

Орос 14-р сургууль орчим

Ажлын явц:

- Барилга угсралтын ажил-91%
- Материал ханган нийлүүлэлт- 100%

Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТЭТГ-аас 2018 оны 07 сарын 17-нд авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 543 метр урттай Ф400мм-ийн зөвлөн ширмэн ариутгах татуургын шугамнаас 460 метр шугам суурилуулаад байна. Үлдсэн хэсэгт 2 гражыг нүүлгэн шилжүүлэх, зөвшилцөх ажил хийгдэж буй тул ажлыг түр зогсоосон. Барилга угсралтын ажлын нийт явц 91%-тай хэрэгжиж байна.



Төв коллекторт холбохын тулд Энхтайвны өргөн чөлөөний хөдөлгөөний эрчим өндөртэй автозам доогуур 45м орчим сувэлж суурилуулт хийсэн.

5. СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 8-Р ХОРОО, БАЯНХОШУУ ДЭД ТӨВД БАРИХ БИЗНЕС ИНКУБАТОР, МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН БАРИЛГА

Гэрээний дугаар: BSDF05, Lot 2
Гүйцэтгэгч: "Томо Бюлдинг" ХХК.
"Би Эм Си Эм" ХХК-иудын түншлэл
Хүчин чадал: Бизнес инкубатор,
сургалт үйлдвэрлэлийн төвийн
барилга
Байршил: Баянхошуу дэд төв
Ажлын явц: 85%

Сонгинохайрхан дүүргийн 8-р хороо, Баянхошуу дэд төвд барьж буй бизнес инкубатор, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилгын газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг Нийслэлийн газрын албанаас 2018 оны 04 сарын 16-ны өдөр, МЗХ2018/07-50 тоот архитектур төлөвлөлтийн даалгаврыг 2018 оны 04 сарын 20-нд, 138/2018 тоот барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2018 оны 05 сарын 07-ны өдөр НХТТГ-аас авсан.



"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр"-ийн Төсөл 1-ийн хүрээнд Азийн Хөгжлийн Банкны 100% хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Баянхошуу дэд төв, Сонгинохайрхан дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт бизнес инкубатор, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн барилга барьж байна. Одоогоор барилгын үндсэн хийцийн угсралтын ажил, барилгын дээвэр, гадна ханын өрлөг шавардлага будгийн ажил, зам талбай, гадна инженерийн шугам сүлжээний угсралт бүрэн дуусч барилгын халаалт авч, дотор заслын ажлыг хийж байна. Барилга угсралтын ажлын явц 85%-тай хэрэгжиж байна.

6. СЭЛБЭ ДЭД ТӨВД УСАН САН, НАСОС СТАНЦЫН БАРИЛГА УГСРАЛТ БОЛОН УС ДАМЖУУЛАХ ШУГАМ ХООЛОЙ НИЙЛҮҮЛЖ, СУУРИЛУУЛАХ АЖИЛ

Гэрээний дугаар: BSWR10, Lot2

Гүйцэтгэгч: "Санжат" ХХК

Хүчин чадал:

- 1000 м³ усан сан
- Насос станц
- Цэвэр усны шугам

Байршил: Сүхбаатар дүүрэг

Ажлын явц: 83%

Барилга угсралтын 228/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТЭТГ-аас 2018 оны 05 сарын 06-ны өдөр авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

1000м³ хүчин чадалтай усан сангийн төмөрбетон хийцийн цутгалт бүрэн хийгдэж, гадна ус тусгаарлалт, дулаан тусгаарлалтын ажлууд бүрэн хийгдсэн. Q=1.042т3/мин x 69 мН хүчин чадалтай ажлын 2, нөөцийн 1 насос бүхий насос станцын барилгын барилга угсралт бүрэн хийгдсэн, 2019 оны хавар урин дулаан орохоор дотор засал болон тоног төхөөрөмж суурилуулах ажил бүрэн хийгдэнэ. Тоноглолын худалдан авалт, таталтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. 1.69 км урт дамжуулах шугамын суурилуулалтын ажил 93 орчим хувьтай хийгдсэн байна.

Хэдийгээр 2018 онд бороо хур элбэгтэй, хөрсний усны түвшин олон жилийн дундажаас дээшилсэн байсан боловч гүйцэтгэгч Санжат ХХК барилга угсралтын ажлыг сайн гүйцэтгэж одоогоор нийт гүйцэтгэлийн явц 83 %-тай хийгдээд байна.





7. БАЯНХОШУУ ДЭД ТӨВИЙГ ТӨВЛӨРСӨН ДУЛААНААР ХАНГАХ ДУЛААНЫ 11И МАГИСТРАЛЬ ШУГАМЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛТИЙН АЖИЛ

Гэрээний дугаар: BHF06

Гүйцэтгэгч: "ЧММ" ХХК, "Эс Энд Эй Трейд"
ХХК-иудын түншлэл

Хүчин чадал:

- 2ф500мм шугамыг 2ф700 болгох 2.1 км
- 2ф400мм шугамыг 2ф600 болгок 1.2 км
- Өргөлтийн насос станц 550м3/ц н=53м


Байршил: "Хөрс" худалдааны төвөөс

ханын материалын эцэс хүртэл

Ажлын явц: 68%

Угралтын ажлын гэрээг ЧММ ХХК, Эс Энд Эй трейд ХХК-ийн түншлэлтэй 2018 оны 03 сарын 09-нд байгуулж, ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг Эрчим Хүчний Яамнаас 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр авсан.

Дулааны 11и магистраль 2ф500мм-ийн 1.6 км шугамыг буулгаж 2ф700мм болгон өргөтгөж, шинэчлэх ажлыг бүрэн хийж дуусгасан. Тохижилт нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. 2019 оны 05 сараас Содон хорооллын хойд уулзвараас ханын материалын эцэс хүртэлх 2ф400мм-ийн 1,6км шугамыг буулгаж 2ф600мм болгон өргөтгөж, шинэчилнэ.



Зээлийн еренхий хэлэлцээрийн дагуу дулааны шугаманд ашиглагдах яндан хоолойг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх ажил удаашралтай, олон шат дамжлагатай зэргээс шалтгаалж материал татан авалт хийх бүрт 12-45 хоног зарцуулж байсан нь төлөвлөгөөний дагуу 2018 онд багтаан дуусгаж бүрэн ашиглалтанд оруулах боломжгүй байдалд хүргэсэн. Тиймд, уг шугамын үлдсэн хэсэг болох 1.6км шугамыг 2019 онд буулгаж шинэчлэхээр болгон гэрээг сунгасан. Импортын албан татвараас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх, хугацааг богиносгох талаар эрхэзүйн зохицуулалтыг оновчтой болгох нь цаашид хөтөлберийн хэрэгжилтэнд чухал үр нөлөөтэй. Үлдсэн 1,6км шугамын угсралтанд ашиглах материалын татан авалтыг бүрэн хийж дууссан ба 2019 онд уг шугамыг барьж ашиглалтанд бүрэн оруулах нөхцлийг амжилттай бүрдүүлсэн.

Мөн гүйцэтгэгч байгууллагын зүгээс нэвтрэх сувгууд, трассыг өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх ажлуудыг бүрэн гүйцэтгэж бэлтгэл ажлыг бүрэн хангасан болно.

8. УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ДУГУЙ РЕЗЕРВУАРЫН БАРИЛГА БОЛОН АЭРОТАНКИЙН БЕТОН ХИЙЦИЙН ШИНЭЧЛЭЛТИЙН АЖИЛ

Гэрээний дугаар: WWTPR01
Гүйцэтгэгч: "Эс Энд Эй Трейд" ХХК.
"Набсан" ХХК-иудын түншлэл
Байршил: СХД-ийн 20-р хороо.
Ажлын явц: 68%

Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн дугуй резервуарын барилгыг дотор инженерийн шугам сүлжээний хамт шинэчлэн барих болон аэротанкийн бетон хийцийн эвдрэлийг засах, цэвэрлэгээний чанарыг сайжруулах агаарын диффузер, селектор нэмж суурилуулах ажлын гүйцэтгэл 68%-тай үргэлжилж байна.

Аэротанкийн хувьд: 1 дүгээр аэротанкийг 4 дүгээр сарын 15-наас бэлтгэл ажил ханган ойролцоогоор 1 сарын хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажилласан. Суллах үйл ажиллагаа, цэвэрлэгээ, бетон хийцийн хийцлэл/зураг тесэл, угсралтын технологийг сайжруулах/, шинээр суурилуулах селектор, холигч, диффузэр зэргээс хамаарч төлөвлөсөн хугацаанаас нэг сараар хоцорч ашиглалтанд оруулсан. Нэгдүгээр аэротанкийн ажлаас хангалттай туршлага хуримтлуулсан тул 2018 оны 07 сарын 25-наас 2 болон 3-р аэротанкийн засварын ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Улсын баяр наадам зохион байгуулахтай холбогдуулан БХБЯ-ны дэд сайдаас өгсөн чиглэлийн дагуу БУА нь 2018.07.05-аас 2018.07.23 хооронд бүрэнзогссон.



1950-иад онд баригдсан анхдагч сараалжны зориулалттай дугуй резервуарын барилгыг бүрэн буулгаж, буцааж шинээр барих угсралтын ажил бүрэн дууссан ба дотор ИШС болон дотор заслын ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Өвлийн улиралд гадаа ажиллах нөхцөлгүй болсон тул гадна фасадын ажлыг ирэх хавар хийхээр төлөвлөсөн. Дугуй резервуарын барилгыг 2019 онд аэротанк №4, №5-ын засварын ажил бүрэн дууссаны дараа байнгын ашиглалтанд хүлээлгэн өгөх юм.

Дугуй резервуарын барилгыг өмчөөс хасах шийдвэр гаргуулах, барилгыг буулгах зөвшөөрөл авахад тодорхой хугацаа алдсан болно.

9. БАЯНХОШУУ ДЭД ТӨВД УСАН САН, НАСОС СТАНЦЫН БАРИЛГА УГСРАЛТ БОЛОН УС ХАНГАМЖИЙН ШУГАМ ХООЛОЙ НИЙЛҮҮЛЖ, СУУРИЛУУЛАХ АЖИЛ

Гэрээндийн дугаар: BSWR10, Lot1

Гүйцэтгэгч: "Бумбод" ХХК,

"Одкон" ХХК-иудын түншлэл

Байршил: БГД 22-хороо

Самбалхүндэв уулын оройд

Хүчин чадал:

- 1000 м³ Усан сан
- 1-р даралт өргөх насос станц
- Өргөлтийн насос станц
- Ус дамжуулах хоолой

Барилга угсралтын 104/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТЭТГ-аас 2018 оны 04 сарын 25-нд авч барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.

Цэвэр ус дамжуулах шугамын батлагдсан трасст 2017 оны 07 сараас 09 сарын хооронд УИХ гишүүн Ж.Ганбаатарын хөрөнгөөр Баянгол дүүргийн 9, 10-р хорооны заагт хатуу хучилттай авто зам барьж ашиглалтанд оруулсан байгаа нь шугам суурилуулах ажлыг хүндрэлтэй, мөн үр ашиггүй нэмэлт зардал шаардах нөхцлийг үүсгэсэн тул трассыг ашиглагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран шинээр тодорхойлж ус дамжуулах шугам, 2-р өргөлтийн насос станцын зураг төслийг Хайдро Дизайн Прожект ХХК-иар гүйцэтгүүлсэн.



1000м³ хүчин чадалтай усан сангийн төмөрбетон хийцийн цутгалт бүрэн хийгдсэн. Q=1,042т 3/мин x 69 тН хүчин чадалтай ажлын 2, нөөцийн 1 насос бүхий насос станцын барилгын барилга угсралт бүрэн хийгдсэн, 2019 оны хавар урин дулаан орохоор дотор засал болон тоног төхөөрөмж суурилуулах ажлыг хийж дуусгана. Тоноглолын худалдан авалт, таталтын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. 3.65 км урт дамжуулах шугамын суурилуулалтын ажил 95 орчим хувьтай хийгдсэн байна. Гүйцэтгэгч Бумбод ХХК болон Одкон Холдинг ХХК-тай 2017 оны 12 дугаар сард гэрээ байгуулсан ба ажлын гүйцэтгэлийн явц 57 %-тай байна



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРОСЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТЕЛБАР

10. СЭЛБЭ ДЭД ТӨВД БАРИГДАХ АВТО ЗАМ, ДУЛААНЫ БОЛОН ДЭД БҮТЦИЙН ШУГАМ СУЛЖЭЭНИЙ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ҮЕ ШАТ 2

Гэрээний дугаар: SRDH14

Гүйцэтгэгч: "Набсан" ХХК, "Тэргүүн инвест" ХХК,

"Тэгш плант" ХХК-иудын түншлэл

Байршил: Чингэлтэй дүүргийн 14, 18-р хороо.

Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороо

Барилга угсралтын ажлын явц: 32.6%

Хүчин чадал:

- Авто зам 1.9 км
- Гадаргын ус зайлцуулах суваг 2.4 км
- Автозамын гэрэлтүүлэг 4.7 км
- Цэвэр усны шугам хоолой 2.0 км
- Бохир усны шугам хоолой 4.2 км
- Дулаан дамжуулах шугам хоолой 4.6 км /6ш УДДТ

Набсан ХХК, Тэгш Плант болон Тэргүүн Инвест ХХК-иудын түншлэлийн 244/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТЭТГ-аас 2018 оны 06 сарын 08-ны өдөр авч, нүүлгэн шилжүүлэлт хийсэн хэсэгт ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажлын явц 32.6%-тай хэрэгжиж байна.

Үерийн хамгаалалтын сувагтай огтлолцож байгаа болон давхцаж байгаа бохир, цэвэр усны шугамын барилга угсралтын ажлыг түрүүлэн хийснээр үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг гүйцэтгэгч компани ажлаа бүрэн дуусгах боломжийг бүрдүүлсэн.

Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн зөвшилцөх явц, нөхөн олговор олгох явц удаашралтай байсан хэдий ч дээрх түншлэл нь 2018 оны барилга угсралтын улиралд чөлөөлөгдсөн нэгж талбарыг бүрэн цэвэрлэж, автозам шугам сүлжээний трасст өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх ажлын 90 гаруй хувьтай гүйцэтгэн бэлтгэл ажлыг хангасан.

Мен Ариутгах татуургын 1.10 км шугам, 2 ширхэг Ус дулаан дамжуулах төвийн барилгын угсралтын ажлуудыг хийж гүйцэтгээд байна.



11. СЭЛБЭ ДЭД ТӨВД БАРИГДАХ АВТО ЗАМ, ДУЛААНЫ БОЛОН ДЭД БҮТЦИЙН ШУГАМ СУЛЖЭЭНИЙ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ҮЕ ШАТ 1

Гэрээний дугаар: SRDH11

Гүйцэтгэгч: "Вайт Финикс" ХХК, "Хасу Мегаватт" ХХК, "Эвт Трак" ХХК-иудын түншлэл

Байршил: Чингэлтэй дүүргийн 14, 18-р хороо, Сүхбаатар дүүргийн 13, 14-р хороо

Ажлын явц: 40%

Хүчин чадал:

- Авто зам 3.7 км
- Гадаргын зайлцуулах суваг 2.0 км
- Гудамж, автозамын гэрэлтүүлэг 7.5км
- Цэвэр усны шугам хоолой 3.9 км
- Бохир усны шугам хоолой 5.5 км
- Дулаан дамжуулах шугам хоолой 4.4 км /8ш

Вайт финикс ХХК, Хасу Мегаватт ХХК болон Эвт Трак ХХК-иудын түншлэлийн 243/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТТГ-аас 2018 оны 06 сарын 08-ны өдөр авч, ажлууд хоорондын уялдаа холбоог ханган үерийн хамгаалалтын сувагтай огтлолцож байгаа болон давхцаж байгаа бохир усны шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.



Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн зөвшилцөх явц, нөхөн олговор олгох явц удаашралтай байсан хэдий ч дээрх түншлэл нь 2018 оны барилга угсралтын улиралд чөлөөлөгдсөн нэгж талбарыг бүрэн цэвэрлэж, автозам шугам сүлжээний трасст өртсөн цахилгаан холбооны шугамыг зөөж шилжүүлэх ажлыг 95 гаруй хувьтай хийн бэлтгэл ажлыг хангасан.

Мөн ариутгах татуургын 1.31км Ø250-200 шугам, цэвэр усны 0.60км Ø200 шугам, дулаан хангамжийн 0.46км шугам болон 4 ширхэг Ус дулаан дамжуулах төвийн барилгын угсралт болон 0.60км автозамын далангийн 2 үе нягтруулгыг хийж гүйцэтгээд байна. 2018 оны 11 сарын 30-ны байдлаар барилга угсралтын ажлын нийт гүйцэтгэл **40.0%** байна.

**12. СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ДУЛААНЫ СТАНЦЫН
ЗУРАГ ТӨСӨЛ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТ,
БАРИЛГА УГСРАЛТЫГ ГҮЙЦЭТГЭХ
ТҮЛХҮҮР ГАРДУУЛАХ НӨХЦӨЛТЭЙ ГЭРЭЭ**

Гэрээний дугаар: SHF06

Гүйцэтгэгч: "Хүрд" ХК, "Шиншиан

Гонгшен бойлер" ХХК-ийн түншлэл

Байршил: Сүхбаатар дүүрэг 13-р хороо

Хүчин чадал: 26.68 МВТ дулааны

станц

Барилга угсралтын ажлын явц: 27%

2017.07.07 өдөр "Хүрд" ХХК, "Шиншиан Гонгшен бойлер" ХХК-ийн түншлэлтэй гэрээ байгуулж зураг төслийн ажлыг эхлүүлсэн. Гэрээний нөхцөл ёсоор 2018.11.24-ны өдөр Нийслэлээс урьдчилгаа төлбөр шилжсэнээр гэрээ хүчин төгөлдөр болж гэрээний эхлэх өдөр тоологдсон. Гүйцэтгэгчтэй хийсэн олон удаагийн уулзалтаар БНХАУ-ын "Шиншиан Гонгшен бойлер" ХХК зураг төслийг боловсруулж буйгэж удаа дараа мэдэгдсэн боловч уг компани нь зураг төслийг гүйцэтгэхдээ төлөвлөсөн хугацаанаас хоцорсон. Иймд, 2018 оны 03 сарын 15-наас түншлэлийн толгой компани болох "Хүрд" ХК нь вөрсдөв Монголд ажлын зураг төслийг боловсруулахаар болж "Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн"-гээр гүйцэтгүүлж байгаа бөгөөд боловсруулсан зураг төслийг Эрчим Хүчний Хөгжлийн төвөөр магадлал хийлгэх ажил удаашралтай байна.

Захиалагчийн зүгээс 2018.11.16-нд түншлэлийн 2 компанийд ажил зогсоох мэдэгдэл хүргүүлээд байна. Хугацааны алдангийг тооцсон мэдэгдлийг 2018 оны 07 сард хургүүлсэн, алдангийн хэмжээ нь дээд хязгаар





13. УЛААНБААТАР ХОТЫН ЗҮҮН ХОЙД БУСИЙН УСАН САНГААС ТАСГАНЫ УСАН САН ХҮРТЭЛХ HDPE Ф900ММ-ИЙН 4010 МЕТР ЦЭВЭР УС ДАМЖУУЛАХ ГОЛ ШУГАМЫН БОЛОН Ф600ММ-ИЙН 1684.23 МЕТР УРТ «9Б» БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ЗӨӨЛӨН ШИРМЭН ЯНДАН ХООЛОЙ ШУГАМЫН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ

Гэрээнд дугаар: WSNR10A

Гүйцэтгэгч: "Грийн ресурс" ХХК

Байршил: КТМС-н усан сангаас 100 айл.

Баянбүрдийн тойрог, Тасганы усан сан

Хүчин чадал:

• ф900мм-н цэвэр ус дамжуулах
HDPE хоолой – 4010 м

• ф600мм-н бохир ус зайлцуулах
зөвлөн ширмэн хоолой – 1684.23 м

Ажлын явц:

• Барилга угсралтын
ажил-14%

• Материал ханган
нийлүүлэлт- 10%



Үйлдвэрлэлийн хяналтын хүрээнд 2018 оны 06 дугаар сарын 07-11-ний хооронд БНХАУ-ын Шандун мужийн Linyi хотын Teng Yuan үйлдвэр дэх D900 SDR17 PE-10 яндан хоолойн үйлдвэрлэлийн явц, хөндлөнгийн хяналтын SGS (Tianjin) шалгалтын сорьц, баталгаажилт, 4 төрлийн хэмжилт тестийг үйлдвэр дээр хийлгүүлж, үлдсэн туршилтуудын SGS лабораторийн хяналтыг хийлгүүлж тайланг 2018 оны 07 сарын 23-нд хүлээн авав.

162/2018 тоот ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТETГ-аас 2018 оны 05 сарын 14-нд авсан. Бусад бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Үүнд: Одоогоор барилга угсралтын талбайд 400м урт HDPE ф900мм цэвэр усны хоолой орж ирсэн. 960м урт зөвлөн ширмэн ф600мм яндан хоолой буусан байна. БНХАУ Эрээн хотын боомт дээр дараагийн ээлжийн 1200м урт HDPE ф900мм цэвэр усны яндан, 724м урт зөвлөн ширмэн ф600мм яндан хоолой нааш дамжуулж ачигдахад бэлэн болоод байна.

Цэвэр усны яндан хоолой нь БНХАУ-ын Шандун мужийн Linyi хотын Teng Yuan үйлдвэрт үйлдвэрлэгдсэн, хөндлөнгийн SGS (Tianjin) лабораториар баталгаажсан болно. Барилга угсралтын ажил удаашралтай байгаа гол шалгаан нь имэртын албан татвараас чөлөөлөгдөх явц удаашралтай, олон шат дамжлагатай байгаагаас хугацаа алдаж байна.

Гүйцэтгэгч Грийн Ресурс ХХК зүгээс энэ онд цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийгээд байна. Барилгын ажилд ашиглагдах бүх бараа материалыг өвлийн улиралд татан авч неецлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Мөн газар чөлөөлөлт, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажлууд удаашралтай байгаагаас гүйцэтгэгч байгууллага гэрээт ажлаа гүйцэтгэх нөхцөл боломжоор хангагдах боломжгүй байдал бий болж хугацааны хувьд хоцрогдол үүсээд байна.

**14. УЛААНБААТАР ХОТЫН ТАСГАНЫ УСАН САНГААС
3,4-Р ХОРООЛЛЫН УСАН САН, БАРУУН ДҮҮРГИЙН
НАСОС СТАНЦ ХҮРТЭЛХ 7054 МЕТР УРТТАЙ
Ф600ММ-ИЙН ЦЭВЭР УС ДАМЖУУЛАХ ГОЛ ШУГАМЫН
БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ**

Гэрээний дугаар: WSWR17B

Гүйцэтгэгч: "Мон Инж Бар" ххк

Байршил: Ктмс-н усан сангаас 100 АЙЛ,
БАЯНБУРДИЙН ТОЙРОГХҮРТЭЛ

Хүчин чадал:

- ф630мм-н цэвэр ус дамжуулах
- HDPE хоолой – 8070 м
- Холбох хэрэгсэл

Ажлын явц:

- Барилга угсралтын ажил-14%
- Материал хангандийн нийлүүлэлт- 10%



Яндан хоолой хаалт арматур үйлдвэрлэл дуусч, татан авалт хийгдэж байна. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг НХТETГ-аас 2018 оны 06 сарын 05-нд авсан. Одоогоор барилга угсралтын талбайд 335м урт ф600мм цэвэр усны хоолой угсралаад байна.

Барилга угсралтын ажил удаашралтай байгаа гол шалтгаан нь импортын албан татвараас чөлөөлөгдөх явц удаашралтай, олон шат дамжлагатай байгаагаас хугацаа алдаж байна.

Гүйцэтгэгч Мон Инж Бар ХХК, НАБ ХХК-иудын түншлэлийн зүгээс 2018 онд цэвэр усны 3 худгийн цутгалтын ажлыг хийгээд байна. Энэ өвөл хавар ирэх онд ашиглагдах бараа материалыг нөөцлөх төлөвлөгөөтэй. Мөн газар чөлөөлөлт, нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлөх ажлууд удаашралтай байгаагаас гүйцэтгэгч байгууллага гэрээт ажлаа явуулах нөхцөл боломжоор хангагдах боломжгүй болж, хугацаа алдсан асуудал үүссэн.



3. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн Худалдан Авах Ажиллагаа (ХАА) нь Нийслэлийн Худалдан Авах Ажиллагааны Газраар (НХААГ) дамжих үйл явцыг болиулж. ХАА-г Төсөл хэрэгжүүлэгч нэгж (ТХН)-д 2018 оны 7-р сараас эхлэн шилжүүлсэн нь ажлыг бодино хугацаанд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж Азийн Хөгжлийн Банк (АХБ). ТХН болон НЗДТГ хооронд олон шатлал дамжих шаардлагагүй болгосон.

Төслийн 1 үе шатны хүрээнд АХБ болсон ЕХОБ-ны санхүүжилтийн 4 төрлийн эх үүсвэрээс нийт 36 багц худалдан авалтын төрөл байгаагаас 2018 оны 11-р сарын байдлаар 30 багцын худалдан авах ажиллагааг гүйцэтгэж, гэрээ байгуулсан. Үүнээс 8 багц бүрэн гүйцэтгэж дууссан ба эдгээр нь доорх 6 төрлийн барилга угсралтын ажил. 2 төрлийн барааны ханган нийлүүлэлт болно:

1. NCB-BCM1: 4116 метр DM450&500-ийн зөвлөн ширмэн (3Ш) хоолойтой Баянхшууны 1-р хэсгийн өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажил;
2. NCB-BCM2: Баянхшууны ариутгах татуургын 2-р хэсгийн зөвлөн ширмэн (3Ш) хоолой бүхий 2250 метр ариутгах татуургын барилгын ажил;
3. NCB-SCM03: Сэлбийн 2183 М DN400-ийн зөвлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын барилгын ажил;
4. WWOI: УСУГ-ын үйл ажиллагааг сайжруулах дэд төсөл хэрэгжүүлэх;
5. BSDF07A: Баянхшуу дэд төвд үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт болон YXC-ийн хамгаалалтын хайсны угсралт суурилуултын ажил-багц 1;
6. BSF05: Баянхшуу дэд төвд баригдах цэцэрлэгийн барилга угсралтын ажил - багц 1. мөн
7. BSPE: Сэлбэ, Баянхшуу дэд төвд ус хангамж, ариутгах татуургын яндан хоолой нийлүүлэх
8. BFKA: Баянхшуу дэд төвд баригдах цэцэрлэгт тавилга, гол тогооны болон бусад төрлийн тоног төхөөрөмжөөр хангах

Одоогоор Төслийн 1-р үе шатны ХАА-ны хүрээнд үнэлгээний шатанд явагдаж буй нийт 2 тендер, зарлагдах нийт 3 тендер байна. Үүнд:

ҮНЭЛГЭЭНИЙ ШАТАНД:

Сэлбэ болон Баянхшуу дэд төвийн үерийн далан дагуух тохижилтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2017 оны 12-р сарын 22-нд зарлаж, 2018 оны 2-р сарын 6-нд тендер хүлээн авсан. Үнэлгээний хороо ажиллан үнэлгээ хийж, тайлан боловсруулж байна.



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛТЫГ ХӨГЖҮҮЛЭХ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ХӨТЕЛБЭР

4. ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ БА НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ

Монгол улсын засгийн газар (МУЗГ) болон Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хооронд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан "Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр"-т зааснаар Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийг АХБ-ны "Хамгааллын бодлого"-ын дагуу боловсруулсан "Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг"-т нийцүүлэн гүйцэтгэх ба тус ажилтай холбогдон гарах зардлыг МУЗГ бүрэн хариуцах үүрэгтэй гэж заасан байдаг.

Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын баримт бичиг буюу Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (ГЧНШТ)-г батлагдсан зурагтеслийг гүндэслэн Нийслэл болон түүний харьяа байгууллагууд боловсруулан АХБ-аар хянуулж батлуулах үүрэгтэй.

Тус үүргийн дагуу төслийн 1 дүгээр үе шатны хувьд Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн 7 төлөвлөгөө боловсруулан батлуулсан ба Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж байна.

Тус баримт бичгүүд нь АХБ-ны вэб дээр тавигдсан. Холбоос: <https://www.adb.org/projects/45007-004/main#project-documents>

А. ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН АЖЛЫН ЯВЦ

Төслийн 1 дүгээр үе шатны газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн явц 2018 оны 11 сарын 30-ны байдлаар:

- 816 нэгж талбар эзэдтэй зөвшилцэлд хүрснээс
- 689 нэгж талбарын нөхөн олговор олгох тухай НЭД-ын захирамж гарч
- 650 нэгж талбарын нөхөн олговор олгогдоод байна.

Иргэдтэй зөвшилцэх ажлын явц 94.3% боловч нийт зөвшилцсэн иргэдийн нөхөн олговор олгох ажлын явц 84.5%-тай байна.

№	Байршил	Ажлын нэр	Нийтийн орчиний тайлбар			Зөвлөхүүс	Захирагчдын гаралт	Захирагчийн төслийн санал	Зөвлөхүүстүй Удзсийн	Захирагчийн төслийн оруулсан төслийн санал	Нийтийн тайлбар төслийн тайлбар	Захирагчийн дүн
			Нийт	шаг	бүтэй							
1	Банкшууд хийтийн	Зам, инженерийн шурэм сургалт	334	17	117	317	381	0	17	22	276	8,866,552,560
		Цэвэрэг, МСҮТ, Цахилгааны ЦҮМБийн цэвэрэг	27		27	27	27	0	0	0	27	1,145,465,138
		Усан сан	13	1	12	11	11	0	0	0	11	291,491,344
		Дундажын төхөөрөмжийн дундажын төхөөрөмжийн 3.2 км шурэм	46	36	9	38	9	0	2	39	5	957,777,131
2	Сандыг тий	Зам, инженерийн шурэм сургалт	335	142	153	385	235	0	34	38	235	13,158,103,817
		Дундажын санал	27		27	27	27	0	0	0	27	1,843,670,339
		Цэвэрэг, МСҮТ	19		19	19	19	0	0	0	19	1,418,113,026
3	ХТМС-с Тамчилч хурданшиг цэвэр башар усны 11 км шурэм	15	13	2		0	0	15				
			216	409	346	744	839	0	74	89	450	27,682,994,355
4	Башар усны инженерийн	Нийт										128,797,555
												28,990,363,710

Хүснэгт 3. Газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэлтийн явц

5. ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар төслийн санхүүжилтийн ашиглалт дараах байдалтай байна. Үүнд:

Төслийн Сангийн яамны гадаад зээлийн тусlamжийн эх үүсвэрийн ашиглалт 33.08 тэрбумтөгрөг ба 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэл буюу нийт зарцуулалт нийт 34.63 тэрбум төгрөг байна. Мөн нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан 30.33 тэрбум төгрөгийн төсвийн захирамжын зарцуулалт 29.72 тэрбум, олгосон санхүүжилтийн зарцуулалт 27.78 тэрбум төгрөг тус тус байна.

6. ДҮГНЭЛТ, АСУУДЛУУД

2018 оны 12-р сарын 31-ны байдлаар төслийн нэгдүгээр үе шатны хэрэгжилт 69.34 %-тай (Худалдан авах ажиллагааны хэрэгжилт 94.57%, газар чөлөөлөлт нүүлгэн шилжүүлэх ажлын хэрэгжилт 94.12%, барилга угсралтын ажлын хэрэгжилт 52.22%) байна. Бүтээн байгуулалтын ажилтай уялдан барилга угсралтын зарим ажил нэмэгдсэнтэй холбоотойгоор худалдан авах ажиллагаанд багц нэмэгдэж байгаа болон газар чөлөөлөлтөнд өртсөн иргэдэд нөхөн олговор олгох санхүүжилтийн эх үүсвэргүй болсон нь худалдан авах ажиллагаа, газар чөлөөлөлтийн ажлын хэрэгжилтэнд нөлөөлсөн. Нэмэлт ажлуудыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулж сонгон шалгаруулалтын явцыг 11 дүгээр сард эхлүүлсэн бөгөөд төслийн худалдан авах ажиллагааг 2019 оны хоёрдугаар хагаст бүрэн дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

2018 онд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн айлуудад олгох нөхөн олговрын эх үүсвэр дууссанаар 2019 онд нөхөн олговрыг олгохоор болсон. Хугацаа алдахаас сэргийлэх үүднээс Нийслэлийн Газрын алба болон Нийслэлийн Төрийн санхүү, удирдлагын газартай нягт хамтран ажиллаж газар чөлөөлөлтөнд өртсөн иргэдэд нөхөн олговрыг аль болох 2019 оны эхний улиралд багтаан олгуулахаар зорьж байна. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн ажлуудыг 2019 оны төсвееөс нөхөн олговрыг олгож эхэлсэнээр бүрэн хэрэгжүүлж дуусгах ба ингэснээр 2019 оны барилгын улиралд багтаан барилга угсралтын ажлуудыг бүрэн дуусгах боломжтой болно.